

ИНТЕРНАЦИОНАЛЬЧ ҮЙЛСТЭН, КОММУНИСТ ЗҮТГЭЛТЭН

КОММУНИСТ—ИНТЕРНАЦИОНАЛЧ ЦЮЙ-ЦЮБО**(Төрсний нь 80 жилд)**

ХКН-ын гарамгай онолч, удирдагч, зохион байгуулагчдын нэг олон улсын коммунист хөдөлгөөний нэрт зүтгэлтэн, цогт нийтлэлч, зохиолч Цюй Цюбо 1899 оны 1-р сарын 29-нд төржээ.

Үлэмж өргөн цар хүрээтэйгээрээ ялгарах Цюй Цюбогийн уран бүтээлийн их өвд шинжлэх ухааны коммунизмын онол, улс төр, эдийн засгийн ухаан, хятадын ба олон улсын ажилчны хөдөлгөөний түүх, тэрчлэн нийтлэл, яруу найраг, үргэлжилсэн үгийн зохиол уран зохиолын шүүмжлэл, марксизм-ленинзмийг үндэслэгчид хийгээд орос, зөвлөлтийн уран зохиолын орчуулга зэрэг олон зуун бүтээл багтдаг юм.

Октябрийн хувьсгалын нөлөөгөөр хятадад өрнөсөн империализмыг эсэргүүцсэн 1919 оны «5р сарын 4»-ний хувьсгалт хөдөлгөөнд Цюй Цюбо идэвхтэй оролцож байсан нь цаашид түүний нийгэм-улс төр, утга зохиолын амьдралтай хувь заяагаа холбохын эхлэл болжээ. Энэ үед тэрээр Орос дахь «большевик хувьсгал»-ын нөлөөг анхааран ажиж, «энэ хувьсгалын мөн чанарыг ойлгох» гэж эрмэлзэж байлаа. Түүний үзэл суртал, улс төрийн хандлагаа сонгон авахад хятадын анхны марксист Ли Дажао хүчтэй нөлөөлсөн байна. Ли Дажао түүнийг хятад дахь анхны марксист дугуйланд элсүүлэн авч, улмаар орос хэлийг чөлөөтэй эзэмшсэн залуу сэтгүүлчийг «Чэньбао» (Өглөөний сонин) хэмээх сонины сурвалжлагчаар Зөвлөлт Орост явахад тус болжээ.

Цюй Цюбогийн ертөнцийг үзэх марксист үзэл төлөвшин тогтоход нөлөөлсөн шийдвэрлэх хүчин зүйлийн нэг бол тэрээр Зөвлөлт Орост 1921- 22 оны үест очиж аугаа их В. И. Ленинтэй уулзсан, 1922 оны 2-р сард ХКН-ын Москвагийн бүлэгт гишүүнээр элссэн явдал юм. Тэр цагаас эхлэн Цюй-Цюбо ухамсарт бүх амьдралаа марксизм-ленинизм, пролетарийн интернационализмын ялалтын төлөө, ХКН-ын марксист-ленинист шугамын төлөө, ЗХУКН-тай эв санааны нэгдэлтэй байх, Зөвлөлт-хятадын ард түмний найрамдлын үйлст зориулсан билээ.

ЗХУ дахь хятадын хэвлэлийн анхны төлөөлөгч Цюй Цюбо Октябрийн социалист их хувьсгалын туршлага, залуу зөвлөлт орны нийгэм-улс төрийн байгуулал, ажилчин тариачны тухай өөрийн ард түмэнд үнэнийг өгүүлж байлаа. Түүний улс төрийн үйл ажиллагаа, уран бүтээлд зөвлөлтийн ард түмэн, коммунист нам, Октябрийн эх орныг гүнээ хүндэтгэсэн үнэнч найрамдлын сэтгэл, жинхэнэ интернационализмын зарчим нэвт шингэсэн байдаг.

1923 оны 1-р сард Цюй Цюбо Москвагаас эх орондоо буцаж ирэнгүүт ХКН-ын ажилд идэвхтэй оролцох боллоо. Залуу хувьсгалчийн зохион байгуулах авьяас, нийтлэлч, онолчийн хурц билэг, марксизм-ленинзмийн зарчимд үнэнч байдаг нь намын нөхдийн дунд түүний нэр хүндийг түргэн дээшлүүлжээ. ХКН түүнийг хамгийн хариуцлагатай тушаалд дэвшүүлж байв. Цюй Цюбо ХКН-ын III их хурлаар Төв Хорооны гишүүн, IV, V, VI их хурлаар төв хорооны бүрэлдэхүүнд, 1927—1929 онд Төв Хорооны улс төрийн товчооны гишүүнээр сонгогдож байсан ба онол улс төрийн «Синь Циннянь» (Шинэ залуучууд), «Цянь-фэн» (Манлай), «Сяп-

дао» (Замч), «Буэрсайвэйкэ» (Большевик) сэтгүүлийн редактороор ажиллаж байсан юм. 1927 оны зун хувьсгалын түр зуурын ялагдал, хямралын үед Цюй Цюбо нь ХКН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн даргын өндөр албан тушаалд сонгогдож байжээ.

ХКН Цюй Цюбогийн удирдлагаар 1927—28 онд өөрийн эгнээг баруун оппортунист, троцкист, устгах үзэлтнүүдээс цэвэрлэж, зохион байгуулалтын хурц хямрал, улс төрийн зөрөлдөөнийг даван туулсан юм. Цюй Цюбо 1928 оны 6-р сард Москвад хуралдсан ХКН-ын VI их хурал дээр ХКН-ын Төв Хорооны улс төрийн тайлан илтгэлийг хийсэн байна. Их хурал дээр Цюй Цюбо 1925—27 оны хятадын хувьсгалын үеийг «империализм, феодализмыг эсэргүүцсэн хөрөнгөтний ардчилсан хувьсгал» гэж дүгнэсэн Коминтерны чиглэлийг хамгаалж, хятадын хувьсгалын хөрөнгөтний ардчилсан үе шатыг дамжихгүй «харайн гарах» гэсэн Мао Зэдүний алдаатай балмад чиг шугамыг шүүмжилсэн юм.

Олон улсын ажилчны ба коммунист хөдөлгөөний нэрт зүтгэлтэн Цюй Цюбо Коминтерны III, IV, VI их хурал, 1922 онд хуралдсан Алс Дорнодын ард түмний их хуралд оролцож, 1926 онд Шанхайд болсон Коминтерны Гүйцэтгэх Хорооны Алс Дорнодын товчооны бүрэлдэхүүнд сонгогдож байжээ. Коминтерны VI их хуралд Цюй Цюбо, В. Страхов гэдэг нууц нэртэй оролцож, колони ба хагас колони орнууд дахь хувьсгалт хөдөлгөөний тухай хавсралт илтгэл тавьж уг асуудлаар их хурлын төгсгөлд үг хэлжээ. Цюй Цюбо: тус хурлын индрээс марксизм-ленинизм, пролетарийн интернационализмын зарчмыг тууштай хамгаалж, «пролетари нарт хөрөнгөтний үндсэрхэх үзэл халдахын эсрэг эвлэршгүй тэмцэхийн зайлшгүйг» тэмдэглэж байв.

Цюй Цюбо Коминтерны Гүйцэтгэх Хорооны гишүүн, тэргүүлэгчээр сонгогдож байснаас гадна Коминтерн дахь хятадын төлөөлөгчдийг олон жил тэргүүлсэн юм. Түүний дэлхийн коммунист хөдөлгөөнийг бэхжүүлэхэд оруулсан хувь нэмрийг олон орны коммунистууд өндөр үнэлдэг. Цюй Цюбог 1935 оны 6-р сарын 18-нд Чан Кайшийн тушаалаар гоминданы алуурчдын гарт амь үрэгдсэн тухай мэдээг хүлээж аваад Коминтерны Гүйцэтгэх Хороо болон Япон, Энэтхэг-хятад, Англи, АНУ, Канад, Германы коммунист намууд тусгай мэдэгдэл гарган хятадын гарамгай хувьсгалчийн дурсгалыг хүндэтгэн тэмдэглэж байв.

Цюй Цюбо, ХКН-ын томоохон зохион байгуулагч байсан төдийгүй, марксизмын гарамгай онолч, ХКН-ын стратеги, тактик ба хятадын хувьсгалын онолын асуудлуудыг боловсруулахад доривтой хувь нэмэр оруулсан олон талын боловсролтой, интернационалч, марксист байлаа. Түүний онолын бүтээл, нийтлэлүүдэд хятадын нийгмийн ангийн бүрэлдэхүүн, хувьсгалын шинж чанар, улс төрийн болон ангийн холбоо нэгдмэл фронтын тухай, зэвсэгт тэмцэл, пролетари нарын манлайлал, ажилчин тариачны холбоо зэрэг хувьсгалт тэмцлийн явц дахь намын өмнө тавигдсан амин чухал асуудал тусгалаа олсон юм. Цюй Цюбогийн онолын өв шинэ дүгнэлт, ажиглалт багагүй агуулсан төдийгүй, тэр үеийн хятадын марксист сэтгэлгээний хөгжлийн ерөнхий түвшинг тусгаж байв.

Хятадад марксизм-ленинизмыг түгээн дэлгэрүүлэх, сурталчлахад Цюй Цюбо ихээхэн хүч чармайлт тавьж, В. И. Лениний нилээд зохиол, Коминтерны программчилсан баримт бичгүүдийг хятад хэлнээ хөрвүүлжээ.

Цюй Цюбогийн онол практикийн үйл ажиллагаа нь ХКН дахь пролетарийн интернационализмын нэн тууштай төлөөлөгчдийн нэг гэдгийг бүрэн дүүрэн нотолж байгаа юм. Үүний зэрэгцээ тэр цагийн хятадын коммунист хөдөлгөөний нийтлэг хэд хэдэн «нялхасын өвчин» тухайлбал, хувьсгалын түргэдүү зан, тэвчээргүй байдлын улмаас зүүний үзэл рүү

хазайх, ажилчин тариачин олон түмний хувьсгалт бололцоо ба улс төрийн ухамсарын түвшингийн тухай хэтрүүлсэн төсөөлөл, дунд давхаргынхны ролийг дутуу үнэлэх зэрэг нь Цюй Цюбогийн онолын үзэл, практик ажилд тусаж байсныг дурдахгүй өнгөрч болохгүй билээ. Гэвч тэр үеийн ХКН-ын удирдлагад ихэд дэлгэрч байсан ийм алдаа нь Цюй Цюбогийн олон улсын коммунист хөдөлгөөн, хятадын хувьсгалын өмнө байгуулсан асар их гавьяаг нь буруулж чадахгүй юм.

1931 оны намар Бүх Хятадын Зөвлөлүүдийн анхдугаар их хурлаар Цюй Цюбо Хятадын зөвлөлт район дахь Гүйцэтгэх Хороонд эчнээ сонгогдож, 1934 оны 1-р сард гэгээрлийн ардын комиссараар томилогджээ. Тэрээр эдгээр албан тушаалд байхдаа өөрийн бүхий л мэдлэг, оргилсон хүч чармайлтаа хятадад шинэ социалист соёлын үндсийг тавихад зориулсан билээ.

Гэтэл өнөөдөр маоист түүх судлал ХКН-ын түүхэн дэх Цюй Цюбогийн ролийг басамжлан доромжилж, гажуудуулахыг элдвээр оролдож байна. Хятадад 50-иад оны эхээр Цюй Цюбогийн уран зохиолын бүтээлийн түүвэр хэвлэгдэж байсан боловч, түүний улс төрийн бүтээлийн өвийг зориуд «мартсан» байв. Энэ бол маогийнхан Цюй Цюбог зөвхөн зохиолч нийтлэлч гэж харуулахыг оролдон түүний намын удирдагч, онолч, коммунист-интернационалч байсныг үгүйсгэх гэсэн хорон муухай оролдлого гэдгийг улирах цаг хугацаа бидэнд харууллаа. «Соёлын хувьсгал» гэгчийн үед Цюй Цюбог ХКН-ын олон гарамгай зүтгэлтний хамт оппортунист, «урвагч» гэж зарлан, шарилыг нь доромжлон хаясан байна.

Цюй Цюбогийн үйл ажиллагаа, уран бүтээл нь пролетарийн интернационализмын зарчимтай салшгүй холбоотой учир маоистууд зөвлөлт хятадын ард түмний найрамдалт уламжлалыг хятадын ард түмний оюун санаанаас арчин хаях гэж оролдохдоо одоо ч гэсэн Цюй Цюбогийн нэрийг маоист «хар дансандаа» байлгасаар байна. Гэлээ ч худлыг үнэн ялж, харыг цагаан дийлдэг хойно, түүний нэр нь мөнхжин, үйлс нь ялан дийлнэ.

Л. Бэгзжав